



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2020 оны 06 сарын 30 өдөр

Дугаар 49

Мандалговь

Хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн 6.2.1, 6.4 дэх хэсгийн 6.4.6 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг. Эрдэнэдалай сумын Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 5,616,600 /таван сая зургаан зуун арван зургаан мянга зургаан зуу/ төгрөгийн балансын үнэтэй, үлдэгдэл өртөггүй эдэлгээний хугацаа дууссан 21-59 ДУА улсын дугаартай УАЗ-2206 маркийн фургон автомашин, 15,327,000 /арван таван сая гурван зуун хорин долоон мянга/ төгрөгийн балансын үнэтэй, үлдэгдэл өртөггүй чулуун барилгыг тус тус акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

Хоёр. Эрдэнэдалай сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал (Л.Буянтогтох)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

- 2.1 Сумын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хөрөнгийг акталж, данснаас хасах, акталснаас гарах материалыг эргэлтийн хөрөнгөнд бүртгэж авахыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах.
- 2.2 Үл хөдлөх хөрөнгийг акталж, чөлөөлсөн газрыг нөхөн сэргээж байгууллагын хэрэгцээнд зориулалтаар нь ашиглах.
- 2.3 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх.
- 2.4 Энэ тогтоолын биелэлтийг 2020 оны 3 дугаар улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

Гурав. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА С.СҮХБААТАР



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2020 оны 06 дугаар сарын
30-ний өдрийн 79 тогтоолын хавсралт

Эрдэнэдалай сумын Ерөнхий боловсролын сургуулийн акталж, данснаас хасах барилгын мэдээлэл

| № | Барилга, байгууламжийн нэр | зориулалт | Хэмжих нэгж | | Ашиглалта д орсон огноо | Ашиглалты н нийт хугацаа /жилээр/ | Балансын үнэ | Хуримтлагдсан элэгдэл | Үлдэгдэл өртөг |
|-----------------|-------------------------------|-----------|--------------------|--------------------|-------------------------------|--|---|---|-------------------|
| | | | Хэм жих нэгж | Биет хэмжэ э | | | | | |
| 1 | Чулуун склад | Агуулах | M2 | 90 | 1960.08.10 | 36 | 15,327,000 | 15,327,000 | - |
| Нийт дүн | | | | | | | 15,327,000 /арван таван сая гурван зуун хорин долоон мянга/ төгрөг | 15,327,000 /арван таван сая гурван зуун хорин долоон мянга/ төгрөг | - |

Эрдэнэдалай сумын Ерөнхий боловсролын сургуулийн акталж, данснаас хасах автомашины мэдээлэл

| № | Тээврийн хэрэгслийн н төрөл | Марк | Улсын бүртгэлийн | | Үйлдвэрлэ сэн он | Ашиглалт ад орсон огноо | Нийт гүйлт /км/ | Балансын үнэ | Хуримтлагдса н элэгдэл | Үлдэгдэл өртөг |
|-----------------|-----------------------------------|--------------|---------------------|--------|---------------------|-------------------------------|--|--|---------------------------|-------------------|
| | | | Сери | дугаар | | | | | | |
| 1 | Суудлын пургон | УАЗ- 2206 | ДУА | 21-59 | 2000 | 7/26/2000 | 19285 4 | 5,616,600 | 5,616,600 | - |
| Нийт дүн | | | | | | | 5,616,600 /таван сая зургаан зуун арван зургаан мянга зургаан зуу/ төгрөг | 5,616,600 /таван сая зургаан зуун арван зургаан мянга зургаан зуу/ төгрөг | - | |